



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/195/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjts@audit.gov.mn
Аудитор: П.Амарсанаа
Утас: 260512 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Мэдээлэл аудит" ХХК
Захирал: Д.Товуудорж
Утас: 70159511 Цахим хаяг: medeeleaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.6.1 Төсвийн төлөвлөлт	16
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.6.3 Нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Аудитын зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
Албан шаардлага.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 04/377
танай _____-ны № _____-т

БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН
ЗАХИРАЛ И.БУДБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгалийн түүхийн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	124,291,708.25	96,580,235.78
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	19,045.99	109,631.98
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,045.99	109,631.98
31213	Арилжааны банкинд дахь харилцах	19,045.99	109,631.98
35	БАРАА МАТЕРИАЛ	124,272,662.26	96,470,603.80
35100	Түүхий эд материал	62,251,063.00	55,214,453.00
35110	Тусгай зориулалттай материал	62,251,063.00	55,214,453.00
35400	Хангамжийн материал	62,021,599.26	41,256,150.80
35410	Бичиг хэргийн материал	16,570,883.00	6,450,253.00
35420	Аж ахуйн материал	23,175,013.76	11,555,295.30
35440	Түлш шатах тослох материал	-	140,000.00
35450	Барилгын засварын материал	2,661,800.00	682,100.00
35470	Бусад хангамжийн материал	19,613,902.50	22,428,502.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,927,020,941.83	8,245,738,019.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,927,020,941.83	8,245,738,019.90
392	Биет хөрөнгө	6,668,660,921.83	6,628,236,626.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,348,717,332.00	5,348,717,332.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(211,720,061.09)	(345,437,994.41)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,566,333.00	23,428,363.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(98,566,333.00)	(15,545,029.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	565,888,432.29	124,536,006.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(534,225,401.30)	(28,137,884.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	299,677,476.54	218,036,491.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(242,414,761.61)	(180,926,733.72)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	1,438,269,979.00	1,476,252,479.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,778,500.00	2,473,714.99
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,778,500.00)	(137,428.62)
39217	Номын фонд	4,467,926.00	4,977,311.00
393	Биет бус хөрөнгө	258,360,020.00	1,617,501,392.91
39301	Програм хангамж	1,452,000.00	345,024.99
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,452,000.00)	(28,752.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	266,060,020.00	1,617,185,120.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(7,700,000.00)	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,051,312,650.08	8,342,318,255.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	360,000.00	-
4136	Бусад өглөг	360,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	360,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,050,952,650.08	8,342,318,255.68
51	Засгийн газрын хувь оролцоо	1,386,169,214.15	1,386,169,214.15
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,386,169,214.15	1,386,169,214.15
51200	Хуримтлагдсан үр дүн	5,111,658,058.73	6,647,208,764.33
51210	Өмнөх үеийн үр дүн	5,111,658,058.73	5,355,843,158.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,291,365,605.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	553,125,377.20	308,940,277.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,051,312,650.08	8,342,318,255.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,154,572,768.99	2,570,265,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	224,304,250.00	1,593,964,700.00
1200	Нийтлэг татварын бус орлого	224,304,250.00	1,593,964,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	224,304,250.00	1,593,964,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	930,268,518.99	976,300,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	875,240,268.00	896,089,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	875,240,268.00	896,089,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,028,250.99	80,211,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,000,000.00	41,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээний нэмэлт орлого	32,028,250.99	38,811,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,120,476,679.58	1,171,175,500.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,120,476,679.58	1,171,175,500.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,082,219,066.18	1,064,563,915.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,744,933.78	579,836,252.04
210101	Үндсэн цалин	450,834,366.12	435,170,981.52
210102	Нэмэгдэл цалин	150,543,228.89	101,752,759.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,182,990.77	42,912,510.78
210104	Урамшуулал	8,184,348.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,027,110.14	78,534,307.81
210201	Тэтгэврийн даатгал	59,787,070.13	54,016,807.81
210202	Тэтгэмжийн даатгал	5,606,552.01	6,129,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,567,342.00	4,903,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,003,913.00	1,225,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,062,233.00	12,258,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,086,471.73	54,236,364.04
210301	Гэрэл, цахилгаан	27,174,018.54	19,907,661.00
210302	Түлш, халаалт	32,268,500.63	31,955,193.12
210303	Цэвэр, бохир ус	2,643,952.56	2,373,509.92
2104	Хангамж, бараа материалын зардал	58,439,948.10	76,662,787.92
210401	Бичиг хэрэг	7,131,475.00	11,444,990.00
210402	Тээвэр, шатахуун	3,008,300.00	2,033,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,647,439.40	3,311,079.46
210405	Хог хаягдал зайлуулах, цэвэрлэх	3,016,000.00	3,198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэхзүйлс	7,078,925.00	46,978,816.00
210408	Бараа материал акталсны зардал	34,557,808.70	9,696,302.46
2105	Нормативт зардал	8,045,965.00	1,386,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,045,965.00	1,386,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,114,607.00	4,545,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	554,140.00	-
210604	Урсгал засвар	4,560,467.00	4,545,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	62,586,364.44	99,149,775.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,985,519.44	90,448,511.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	2,685,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,153,680.00	1,153,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	354,500.00	357,845.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	18,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	506,000.00	1,909,125.00
210807	Газрын төлбөр	1,150,000.00	1,150,000.00
210808	Банкны үйлчилгээний хураамж	72,205.00	269,414.01
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	1,366,460.00	1,176,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	183,173,665.99	170,213,328.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	360,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,211,801.00	2,465,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	172,961,864.99	167,388,328.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,257,613.40	106,611,585.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,760,268.00	29,022,960.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,060,268.00	27,030,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,700,000.00	1,992,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,497,345.40	77,588,625.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /Урсгал/	9,497,345.40	70,613,439.22
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт/	-	6,975,186.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	34,096,089.41	1,399,089,899.29
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	107,724,293.69
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(107,724,293.69)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	34,096,089.41	1,291,365,605.60

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,386,169,214.15	553,125,377.20	5,077,561,969.32	7,016,856,560.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,386,169,214.15	553,125,377.20	5,077,561,969.32	7,016,856,560.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн			34,096,089.41	34,096,089.41
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,386,169,214.15	553,125,377.20	5,111,658,058.73	7,050,952,650.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			244,185,100.00	244,185,100.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,386,169,214.15	553,125,377.20	5,355,843,158.73	7,295,137,750.08
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		(244,185,100.00)		(244,185,100.00)
Тайлант үеийн үр дүн			1,291,365,605.60	1,291,365,605.60
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,386,169,214.15	308,940,277.20	6,647,208,764.33	8,342,318,255.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	933,830,624.99	976,404,840.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	933,830,624.99	976,404,840.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	875,240,268.00	896,089,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	875,240,268.00	896,089,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,590,356.99	80,315,540.99
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,010,056.00	41,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,580,300.99	38,915,540.99
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	927,904,579.00	976,314,255.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	927,904,579.00	976,314,255.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	889,646,965.60	869,702,669.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,034,126.98	579,836,252.04
210101	Үндсэн цалин	460,541,155.13	435,170,981.52
210102	Нэмэгдэл	136,281,220.95	101,752,759.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,027,402.90	42,912,510.78
210104	Үр дүнгийн урамшуулал	8,184,348.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,978,594.94	77,639,587.81
210201	Тэтгэврийн даатгал	56,461,094.94	53,122,087.81
210202	Тэтгэмжийн даатгал	6,129,400.00	6,129,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,903,500.00	4,903,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,225,900.00	1,225,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,258,700.00	12,258,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,851,447.28	54,236,364.04
210301	Гэрэл, цахилгаан	24,296,364.54	19,907,661.00
210302	Түлш, халаалт	27,911,130.18	31,955,193.12
210303	Цэвэр, бохир ус	2,643,952.56	2,373,509.92
2104	Хангамж, бараа материалын зардал	28,780,091.40	30,426,569.46
210401	Бичиг хэрэг	5,358,850.00	1,987,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,008,300.00	2,173,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,647,439.40	3,311,079.46
210404	Ном, хэвлэл	3,016,000.00	3,198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,749,502.00	19,756,590.00
2105	Нормативт зардал	6,035,000.00	5,614,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,035,000.00	5,614,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,941,350.00	5,655,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,484,800.00	1,104,800.00
210604	Урсгал засвар	4,456,550.00	4,550,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,906,515.00	110,850,596.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,756,770.00	99,275,691.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	2,685,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,153,680.00	1,153,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	354,500.00	357,845.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,269,600.00	2,222,625.00
210807	Газрын төлбөр	1,150,000.00	1,150,000.00
210808	Банкны үйлчилгээний хураамж	72,205.00	13,555.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	7,151,760.00	3,992,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,119,840.00	5,443,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	720,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,119,840.00	4,723,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,257,613.40	106,611,585.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,760,268.00	29,022,960.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,060,268.00	27,030,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,700,000.00	1,992,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,497,345.40	77,588,625.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /Урсгал/	9,497,345.40	70,613,439.22
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт/	-	6,975,186.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,926,045.99	90,585.99
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,907,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,907,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,907,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,907,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	19,045.99	90,585.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,045.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,045.99	109,631.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	896,089,300.00	825,475,860.78	(70,613,439.22)	92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	896,089,300.00	825,475,860.78	(70,613,439.22)	92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	851,542,500.00	797,952,900.78	(53,589,599.22)	94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,935,100.00	567,638,584.14	(45,296,515.86)	93
210101	Үндсэн цалин	464,853,000.00	422,973,313.62	(41,879,686.38)	91
210102	Нэмэгдэл	136,253,100.00	101,752,759.74	(34,500,340.26)	75
210103	Унаа болон бусад нөхөн олговор	11,829,000.00	42,912,510.78	31,083,510.78	363
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,746,300.00	76,152,041.14	(6,594,258.86)	92
210201	Тэтгэврийн даатгал	58,228,800.00	51,634,541.14	(6,594,258.86)	89
210202	Тэтгэмжийн даатгал	6,129,400.00	6,129,400.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,903,500.00	4,903,500.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,225,900.00	1,225,900.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	12,258,700.00	12,258,700.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,454,100.00	54,236,364.04	(1,217,735.96)	98
210301	Гэрэл, цахилгаан	15,200,900.00	19,907,661.00	4,706,761.00	131
210302	Түлш, халаалт	37,340,200.00	31,955,193.12	(5,385,006.88)	86
210303	Цэвэр, бохир ус	2,913,000.00	2,373,509.92	(539,490.08)	81
2104	Хангамж, бараа материалын зардал	22,268,600.00	22,240,269.46	(28,330.54)	100
210401	Бичиг хэрэг	6,627,500.00	1,987,300.00	(4,640,200.00)	30
210402	Тээвэр, шатахуун	2,173,600.00	2,173,600.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,869,000.00	3,311,079.46	(557,920.54)	86
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал	2,589,000.00	3,198,000.00	609,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,009,500.00	11,570,290.00	4,560,790.00	165
2105	Нормативт зардал	5,614,500.00	5,614,500.00	-	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,614,500.00	5,614,500.00	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,380,100.00	3,380,100.00	-	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,104,800.00	1,104,800.00	-	100
210604	Урсгал засвар	2,275,300.00	2,275,300.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,417,700.00	63,967,842.00	(449,858.00)	99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,463,800.00	52,406,492.00	(57,308.00)	100
210802	Аудит, баталгаажуулах зардал	2,685,200.00	2,685,200.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	1,511,000.00	1,153,680.00	(357,320.00)	76
210804	Тээврийн хэрэгслийн татвар	366,100.00	357,845.00	(8,255.00)	98
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,000.00	-	(18,000.00)	0
210806	Мэдээлэл, технологийн зардал	2,223,600.00	2,222,625.00	(975.00)	100

210807	Газрын төлбөр	1,150,000.00	1,150,000.00	-	100
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	4,000,000.00	3,992,000.00	(8,000.00)	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,726,100.00	4,723,200.00	(2,900.00)	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,726,100.00	4,723,200.00	(2,900.00)	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,546,800.00	27,522,960.00	(17,023,840.00)	62
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,546,800.00	27,522,960.00	(17,023,840.00)	62
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,054,800.00	27,030,960.00	(17,023,840.00)	61
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	492,000.00	492,000.00	-	100
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	896,089,300.00	825,475,860.78	(70,613,439.22)	92
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	896,089,300.00	825,475,860.78	(70,613,439.22)	92
310001	Улсын төсвөөс санхүүжих	896,089,300.00	825,475,860.78	(70,613,439.22)	92
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	59	52	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	42	35	-	100
620003	Үйлчлэх ажилтан	16	16	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		80,224,955.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		80,224,955.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		71,749,768.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		12,197,667.90
210101	Үндсэн цалин		12,197,667.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,487,546.67
210201	Тэтгэврийн даатгал		1,487,546.67
2104	Хангамж, бараа материалын зардал		8,186,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		8,186,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,275,500.00
210604	Урсгал засвар		2,275,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		46,882,754.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		46,869,199.00
210808	Санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		13,555.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		720,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		720,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,475,186.43
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		1,500,000.00
2132	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		6,975,186.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт/		6,975,186.43
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		80,315,540.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		80,315,540.99
131101	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		41,400,000.00
131104	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		38,915,540.99
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		19,045.99
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		109,631.98
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		52
620001	Удирдах ажилтан		1
620002	Гүйцэтгэх ажилтан		35
620003	Үйлчлэх ажилтан		16

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч этгээдэд зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Мэдээлэл-Аудит ХХК-ийн аудитор Н.Ганданбаавар, аудитор Д.Туяа, аудиторов туслах Ц.Отгонжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгалийн түүхийн музей 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгалийн түүхийн музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх улмаар Ази тивдээ тэргүүлэх зэргийн байгалийн түүхийн музей болоход оршино.

Байгалийн түүхийн музейн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь байгалийн өвийг цуглуулах, бүртгэн баримтжуулах, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг хуулийн хүрээнд хийж гүйцэтгэх, нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэх, хүний оюуны хэрэгцээг хангах зорилгоор байгаль, түүний бодит гэрч болох зүйлийг дэлгэн үзүүлэх, сурталчлах үйл ажиллагааг явуулах юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Музейн тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх;
- Соёлын тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бүртгэл мэдээлэл, дотоод хяналтын хэлтэс нь 2021 онд хийхээр төлөвлөсөн боловсролын ажил, ёс зүйн зөвлөл, номын сан, нийтэд үйлчлэх үйлчилгээ гэсэн 4 чиглэлийн дагуу хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлж, чиглэл тус бүрээр зохих дүгнэлт, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хянаж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгалийн түүхийн музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,120,476.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,807.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгалийн түүхийн музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,321,916.0 мянган төгрөгөөр буюу 18.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, бараа материал, эздийн өмчийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19.0	109.6	90.6
Авлага	-	-	-
Бараа материал	124,272.7	96,470.6	(27,802.1)
Үндсэн хөрөнгө	6,927,020.9	8,245,738.0	1,318,717.1
Нийт хөрөнгө	7,051,312.6	8,342,318.3	1,291,005.7
Өр төлбөр	360.0	-	(360.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,050,952.6	8,342,318.3	1,291,365.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,051,312.6	8,342,318.3	1,291,005.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 109.6 мянган төгрөг болж 90.6 мянган төгрөгөөр өссөн нь иргэдэд үйлчлэх үйлчилгээндээ арилжааны банкны пос машины үйлчилгээг нэвтрүүлснээс шалтгаалжээ. Энэ нь музейн үзэгчийн тоо, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,470.6 мянган төгрөг болж 27,802.1 мянган төгрөгөөр буурсан нь тооллогын комиссын санал, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 9,696.3 хөрөнгө акталсан, Соёлын яамнаас цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хандивласан 360.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч мөн бараа материалын оны эхний үлдэгдлээс шинээр үзүүлэг, үзэсгэлэнгийн танхим дэглэхэд материал зарцуулсан зэргээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй, оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,245,738.0 мянган төгрөг болж 1,318,717.1 мянган төгрөгөөр өссөн нь 1,509,809.1 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, 84,020.6 мянган төгрөгийн хөрөнгө дахин үнэлж бүртгэсэн, цаашид ашиглах боломжгүй, хөрөнгийн үлдэх өртөггүй 118,563.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан, 107,724.3 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, тайлант онд 167,388.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой тус тус холбоотой байна.

ТӨБЗГ-ын А1/1608 шийдвэрээр Сангийн сайдын 2013 оны 140 тушаалаар “Түүх соёлын дурсгал, үзмэр, эд өлгийг шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1 хэсэгт заасныг үндэслэн 1364 ширхэг 37,982.5 мянган төгрөгийн музейн үзмэрийг эрх бүхий этгээдийн тогтоосон үнэлгээгээр бүртгэсэн, Богдхаан уулын Дархан цаазат газарт байрлах 66,332м.кв талбайтай 1,464,610.6 мянган төгрөгийн үнэлгээтэй газар эзэмших эрх /биет бус хөрөнгө/ үнэ төлбөргүй хүлээн авч, ТӨБЗГ-ын 445 дугаар тогтоолоор үлдэх өртөггүй боловч цаашид ашиглагдах боломжтой 93 нэр төрлийн 568,926.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж нийт 84,020.6 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн, Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 12 нэр төрлийн 17 ширхэг нийт 7,216.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

ТӨБЗГ-ын А1/762 шийдвэрээр 118 нэр төрлийн 118,292.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассан, ТӨБЗГ-ын 287 дугаар тогтоолоор Чингис хааны музейд 105,785.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгө /газар эзэмших эрх/ балансаас балансад шилжүүлсэн, элэгдлээрээ өртгөө нөхсөн Иж-18 маркийн 271.3 мянган төгрөгийн шувууны буу акталж, данснаас хассан, ТӨБЗГ-ын А1/1669, А1/1977 шийдвэрээр Монголын үндэсний музейд 3,620.0 мянган төгрөгийн хөрөнгө, Соёлын өвийн үндэсний төвд 10,860.0 мянган төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжүүлж данс бүртгэлээс хассан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 360.0 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлийг бүрэн барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,342,318.3 мянган төгрөг болж 1,291,365.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,415,692.6 мянган төгрөгөөр буюу 123 хувиар өссөн, энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 50,698.8 мянган төгрөгөөр буюу 4 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 905,571.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 905,571.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 9,482.1 мянган төгрөгөөр бууруулж 896,089.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөр 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр 896,089.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 896,089.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 896,089.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 825,475.9 мянган төгрөгийг зарцуулж, 70,613.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 825,475.9 мянган төгрөг буюу 92 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 51,890.8 мянга, үйл ажиллагаатай холбоотой тогтмол зардлыг 1,217.8 мянга, хангамж, бараа материалын зардлыг 28.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 449.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.9 мянга, бусад урсгал шилжүүлгийг 17,023.8 мянга, нийт 70,613.4 төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь 4 хөтөлбөрийн 70,613.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71702-80101	Соёл урлаг-Үндсэн үйл ажиллагааны зардал	807,022.8	753,490.4	53,532.4	93.4
2	71702-80215	Соёл урлаг-Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	13,483.1	13,472.9	10.3	99.9
3	71702-80219	Соёл урлаг-Харуул хамгаалалтын зардал	29,700.0	29,700.0	-	100.0
4	71702-80802	Соёл урлаг-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	44,546.8	27,523.0	17,023.8	61.8
5	71702-81908	Соёл урлаг-Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	1,336.6	1,289.7	46.9	96.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас “Монгол орны стратиграфийн нэгдсэн /хроно-био-литолог/ ангилал боловсруулж геологийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх нь” төсөлд 41,400.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 38,915.5 мянган төгрөг, нийт 80,315.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 13,685.2 мянга, хангамж бараа, материалын зардалд 8,186.3 мянга, эд хогшил худалдан авах зардалд 2,275.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 46,882.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 720.0 мянга, бусад урсгал шилжүүлэгт 1,500.0 мянга нийт 73,249.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 6,975.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 90.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа болон бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт ороогүй. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2021 онд нийт 1,021,419.5 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5 мэдээллийн хугацаа болоогүй, 10,583.3 мянган төгрөгийн

4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй боловч цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, нэг удаагийн тэтгэмжийн зардлаас бусад зардлын батлагдсан төсөвт 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар илрүүлсэн үзмэрийн орлогоос банканд тушаасан шимтгэл 9.7 мянган төгрөгийг хассаж орлогоо тайлагнасан, шилэн дансны мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан 2 алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгснийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад, 4 мэдээлэл хоцроож алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 360.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	360.0	1	360.0		1		197.2
Зөвлөмж	1		1					100.0
Нийт дүн	2	360.0	2	360.0		0		99.1

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн өөрчлөлт оруулах хүсэлтээ Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн газарт 2022 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 26 тоот албан бичгээр хүргүүлсэн асуудлыг дараагийн аудитаар үзэх шаардлагатай гэж үзэв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,597.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,887.8 мянган төгрөгийн алдааг залруулж, цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж 3,710.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 3,710.0 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 16,807.1 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Аудитаар авлага дансанд бүртгэлтэй татаас санхүүжилтийн авлага 6,975.2 мянган төгрөг, бусад тооцооны авлага 912.6 мянган төгрөг нийт 7,887.8 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогоос 6,975.2 мянган төгрөгийг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал данснаас 912.6 мянган төгрөгийг тус тус залруулж санхүүгийн тайланг зассан.

4.2 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цахим төлбөрийн баримт /И-баримт/-аар баталгаажуулж 3,710.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээ хийгдсэн тухай бүр гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Байгалийн түүхийн музей	АХГ-2022/195/НА-СТА-ТШЗ	Цахим төлбөрийн баримтаар /И-баримт/ баталгаажуулах 3,710.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.	Ажил гүйлгээ гарсан тухай бүр гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах зөвлөж өгсөн.	1	3,710.0							1	3,710.0
2	Байгалийн түүхийн музей	АХГ-2022/195/НА-СТА-ТШЗ	Аудитаар авлага дансанд бүртгэлтэй татаас санхүүжилтийн авлага 6,975.2 мянган төгрөг, бусад тооцооны авлага 912.6 мянган төгрөг нийт 7,887.8 мянган төгрөгийн авах боломжгүй авлагыг санхүүгийн тайланд залруулсан.	Санхүүгийн үр дүнгийн тайланд 7,887.8 мянган төгрөгийн залруулга хийж Санхүүгийн тайланг зассан.	1	7,887.8	1	7,887.8						
	ДҮН				2	11,597.8	1	7,887.8					1	3,710.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Байгалийн түүхийн музей	АХГ-2022/195/НА-СТА-ТШЗ	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл оруулахаас 10,583.3 мянган төгрөгийн 4 мэдээлэл хоцроож байршуулсан байна.	Зөрчлийг бүрэн арилгах, давтан гаргахгүй байх удирдлагад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.	1	10,583.3					1	10,583.3		
	ДҮН				1	10,583.3					1	10,583.3		
НИЙТ ДҮН					3	22,181.1	1	7,887.8			1	10,583.3	1	3,710.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 08 дугаар сарын 25 № 263/А0150458
АХГ-2022/195/НА-СТА-ТШБ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд 10,583,325.00 төгрөгийн ажил, гүйлгээний 4 мэдээлэл хоцроож алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал Байгалийн түүхийн музейн И.Будбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.ТОВУУДОРЖ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-364230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-273.Docx

00108C0835

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.